МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 05 өдөр Дугаар А/153 Мөрөн сум

Төсөл хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Гамшгаас хамгаалах хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21, 32 дугаар зүйлийн 32.1.1 заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Дэлхийн Зөн Монгол” Олон улсын байгууллагын хэрэгжүүлж байгаа “Нэн эмзэг малчин өрхүүдэд зудын эрсдэлд хариу арга хэмжээ авах”, дэмжлэг үзүүлэх төслийг нэмэлтээр Цэцэрлэг, Жаргалант, Галт, сумдад хэрэгжүүлэхийг дэмжсүгэй.

2.Төсөлд хамрагдах дээрх сумдад Засаг даргын орлогчоор ахлуулсан ажлын хэсэг байгуулж төслийн шаардлагад нийцсэн малчин өрхүүдийг сонгож, төслийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт, төсөл, хэрэгжихтэй холбоотой шаардлагатай мэдээ мэдээлэл өгөх, арга зүйн дэмжлэг үзүүлж хамтран ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (М.Хуягбаатар)-д тус тус үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т үүрэг болгосугай.

ДАРГА П.ЛХАГВАЖАВ

Захирамж2024

6712010461